ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/14/НА-СТА-ТТ3

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2023 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsuren. Аудитор: Д.Нарантуул Утас: 99019800. Цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 12
4. АУДИТЫН ТАЙЛАН 14
4.1 Ерөнхий зүйл 14
4.2 Материаллаг байдал 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.25 № 02/115
танай _____-ны №_____-т

ХОВД СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Я.ӨМИРХАН ТАНАА

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд сумын татварын орлогын гүйцэтгэл 340.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй биелж 54.1 сая төгрөгөөр давсан байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 141.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 10.6 сая төгрөг, хөрөнгийн орлого 247.7 сая төгрөг, шууд бус орлого 11.5 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.1 сая төгрөг, бууны албан татвар 1.2 сая төгрөг , улсын тэмдэгтийн хураамж 2.1 сая төгрөг, ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж 128.6 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 0.8 сая төгрөг, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.4 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4.1 сая төгрөг, газрын төлбөр 2.9 сая төгрөг тус тус орлого оруулж, үйл ажиллагааны орлогын татварыг 2.3 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 8.3 сая төгрөгөөр, шууд бус орлогыг 16.3 сая төгрөгөөр бууны албан татварыг 1.0 сая төгрөгөөр тус тус биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1041.8 сая төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 10.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10.8 сая төгрөг, нийт 151.9 сая төгрөгийг хэмнэн зарцуулсантай холбоотой байна.

021020429

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 7/1 тогтоолоор Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хангалттай гэж үнэлсэн байна.

Сумын ЗДТГ нь зорилтын хүрээнд 16 арга хэмжээ, 87 заалтын биелэлтийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 89.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	550,095.60	409,337.30
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	149,162.10	235,634.20
33	**АВЛАГА**	193,550.80	91,317.20
34	**УРЬДЧИЛГАА**	33,690.00	30,000.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	173,692.60	52,385.90
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	7,524,325.30	3,210,128.20
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	7,524,325.30	3,210,128.20
39200	**Биет хөрөнгө**	7,452,885.00	3,207,098.70
39300	**Биет бус хөрөнгө**	71,440.30	3,029.50
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	8,074,420.80	3,619,465.50
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	8,522.20	10,069.30
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	8,522.20	10,069.30
41300	**Өглөг**	8,522.20	10,069.30
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	8,065,898.60	3,609,396.20
51	**Засгийн газрын хувь оролцоо**	8,065,898.60	3,609,396.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,507,216.00	316,625.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,507,216.00	316,625.50
51200	**Хуримтлагдсан үр дүн**	4,869,562.30	3,163,146.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,689,120.30	129,624.20
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	8,074,420.80	3,619,465.50

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	5,233,519.20	1,478,735.20
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	124,217.70	340,318.20
110	**Орлогын албан татвар**	51,048.10	188,153.40
1100	**Хувь хүний орлогын албан татвар**	51,048.10	188,153.40
113	**Хөрөнгийн албан татвар**	1,072.00	11,632.00
118	**Бусад татвар, төлбөр, хураамж**	72,097.60	140,532.90
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	2,046,365.20	397,107.50
120	**Нийтлэг татварын бус орлого**	2,046,365.20	397,107.50
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	3,062,936.40	741,309.50
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	3,410,673.20	1,233,659.40
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	3,410,673.20	1,233,659.40
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	2,689,384.00	1,165,679.40
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	1,725,984.80	370,372.50
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	229,640.00	45,770.30
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	120,823.40	291,232.10
2104	**Хангамж, бараа материалын зардал**	113,913.60	203,940.10

2105	**Норматив зардал**	168,391.50	335.3
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	11,162.20	5,800.50
2107	**Томилолт, зочны зардал**	6,300.00	2,449.20
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	20,147.60	16,451.70
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	293,020.90	229,327.70
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	721,289.20	67,980.10
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	1,822,846.00	245,075.80
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	296.2	4,657,872.60
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	1,822,549.80	-4,412,796.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	6,243,348.80	6,243,348.80
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	6,243,348.80	6,243,348.80
9	**Тайлант үеийн үр дүн**	1,822,549.80	1,822,549.80
10	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	8,065,898.60	8,065,898.60
11	**2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	8,065,898.60	8,065,898.60
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-474,914.90	-474,914.90
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	7,590,983.70	7,590,983.70
19	Тайлант үеийн үр дүн	-4,412,796.80	-4,412,796.80
20	**2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	3,609,396.20	3,609,396.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	3,266,640.80	1,153,287.80
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	124,217.70	340,318.20
110	**Орлогын албан татвар**	51,048.10	188,153.40
1100	**Хувь хүний орлогын албан татвар**	51,048.10	188,153.40
113	**Хөрөнгийн албан татвар**	1,072.00	11,632.00
118	**Бусад татвар, төлбөр, хураамж**	72,097.60	140,532.90
1180	**Бусад нийтлэг төлбөр, хураамж**	2,766.10	7,804.70
1181	**Газрын төлбөр**	402.5	2,912.70
1182	**Байгалийн нөөц ашигласны төлбөр**	68,928.90	129,815.40
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	90,481.20	61,660.10
120	**Нийтлэг татварын бус орлого**	90,481.20	61,660.10

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,051,941.90	751,309.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,130,888.50	897,833.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,130,888.50	897,833.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,394,001.30	806,256.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,728,549.10	368,658.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	232,776.60	47,281.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,515.60	291,232.10
2104	Хангамж, бараа материалын зардал	45,741.60	15,670.70
2105	Норматив зардал	163,103.60	335.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,536.50	6,033.50
2107	Томилолт, зочны зардал	5,580.00	2,449.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,846.40	26,846.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,351.80	47,749.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	736,887.20	91,576.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	135,752.30	255,454.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	75,047.50	168,982.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,047.50	168,982.20
2200	Дотоод эх үүсвэрээр	75,047.50	168,982.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-75,047.50	-168,982.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	60,604.80	86,472.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,557.30	149,162.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,162.10	235,634.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,193,714.80	1,041,818.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,914.30	874,683.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,301.30	785,494.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,327.40	368,357.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,344.20	291,232.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,724.10	15,670.74
2104	Хангамж, бараа материалын зардал	6,033.50	6,033.50
2105	Норматив зардал	89,613.00	89,189.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	196,800.50	167,135.20
2107	Томилолт, зочны зардал	166,655.30	56,485.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,197.90	8,197.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,189.20	21,189.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,613.00	89,189.27

2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	**21,189.20**	**21,189.20**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**196,800.50**	**167,135.20**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**68,423.80**	**68,000.07**
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**21,189.20**	**21,189.20**
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**89,613.00**	**89,189.27**
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**166,655.30**	**56,485.10**
350001	**Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих**	**605.0**	**2,536.0**
350002	**Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих**	**30,959.0**	**53,949.1**
350003	**Урьд оны үлдэгдлээс санхүүжих**	**135,091.3**	
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		**139,410.2**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		**167,586.9**
6	**ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**	**116**	**116**
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	**6**	**6**
610001	Төсвийн байгууллага	6	6
62	**АЖИЛЛАГСАДЫН ТОО**	**55**	**55**
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	30	30
620004	Гэрээт ажилтан	8	8
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**55**	**55**
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	34	34
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**22,609.68**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**22,609.68**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**22,609.68**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**300.00**
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**18,648.80**
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**3,660.90**
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**22,609.70**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**22,609.70**
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,073.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000.02

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн "Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх" эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Ховд сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,455.0 сая төгрөгөөр буюу 44.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	149.2	235.6	(86.5)
Авлага	193.6	91.3	102.2
Урьдчилгаа	1.7	-	1.7
Бараа материал	173.7	52.4	121.3
Үндсэн хөрөнгө	9,005.9	4,295.5	4,710.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**9,524.0**	**4,674.9**	4,849.1
Богино хугацаат өр төлбөр	8.5	10.1	(1.5)
Цэвэр хөрөнгө, өмч	8,065.9	3,609.4	4,456.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	**8,074.4**	**3,619.5**	4,455.0

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, *санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.*

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 149.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 235.6 сая төгрөг болж 86.5 сая төгрөгөөр буюу 58.0 хувиар өссөн нь аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулсантай холбоотой урьд оны давсан орлогыг сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн санхүүгийн дэмжлэгт хуваарилсантай холбоотой өссөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 91.3 сая төгрөг болж, өмнөх оноос 102.2 сая төгрөгөөр *буурсан* байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүсээс авах авлага	193.5	91.3	-102.2
Дүн	**193.5**	**91.3**	**-102.2**

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 102.2 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх санд өмнөх онуудын зээлийн төлбөр барагдсан, улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал			-
Тусгай зориулалтын сан	32.0	30.0	(2.0)
Дүн	**32.0**	**30.0**	(2.0)

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХС-ын малжуулах төслийн зээлийн авлага 2.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 52.3 сая төгрөг болж 121.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Түүхий эд материал	**10.0**	**-**	**10.0**
Тусгай зориулалттай материал	4.7		**4.7**
Эм боох материал	5.3		**5.3**
Хангамжийн материал	**163.5**	**52.3**	**111.2**
Бичиг хэргийн материал	2.1	0.89	**1.2**
Аж ахуйн материал	36.0	42.0	**(6.0)**
Сэлбэг хэрэгсэл	2.4	2.8	**(0.4)**
Барилгын засварын материал	2.1	-	**2.1**
Түлш шатах тослох материал	2.4		**2.4**
Хүнсний материал	9.0		**9.0**
Бусад хангамжийн материал	102.8	0.01	**102.8**
Мал амьтад	6.7	6.6	**0.1**
Нөөцийн бараа	**-**		**-**
Нийт бараа материал	**173.5**	**52.3**	**121.2**

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 52.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 49.6

сая төгрөгийн материалыг зарцуулж, 134.6 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7452.8 сая төгрөг байсан бол оны эцэст 3207.1 сая төгрөг болж 5795.7 сая төгрөгөөр буурсан нь 4314.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8.2 сая, эцсийн үлдэгдэл 10.1 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлан хугацаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс буцаан олгох нөхцөлтэйгөөр 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч тэжээл бэлтгэсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8065.9 сая төгрөг байснаас оны эцэст 3609.4 сая төгрөг болж 4456.5 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн баланс шилжсэнтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1193.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1193.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1327.7 сая төгрөгөөр анх баталж 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны 7/1 тоот тогтоолоор нийт 1193,7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1193.7 сая төгрөгийн төсөв баталснаас 572,1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 345.5 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 156.9 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, Урьд оны үлдэгдлээс 135.1 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,027.10	1,074.50
Орон нутгийн төсвөөс	584.70	572.10
Орон нутгийн хөгжлийн сан	156.90	156.90
Торгуулийн орлого	7.00	5.20
Татварын орлого	278.50	340.30
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	166.61	56.40
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.61	2.40
Туслах үйл ажиллагааны орлогоос	30.90	54.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	135.10	

ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	1,193.71	1,131.0

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 572.1, орон нутгийн татварын болон татварын бус орлого 345.5 ОНХС-ийн санхүүжилт 156.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 56.5, төгрөгийг нийт 1131.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1041.8 сая төгрөгийг зарцуулж 11.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1043.1 сая төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 17.5 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0,9 сая, байр ашиглахтай холбоотой зардал 3.1 сая ,хангамж бараа материал зардалд 0.3 сая төгрөг ,урсгал шилжүүлэг 27.3 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл 49.0 сая төгрөг олгосон байна. нийт 57.6 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.5 сая, хүү торгуулийн орлогоос 5.1 сая төгрөг нийт 5.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл */сая.төгрөг/*

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	291,426.3	345,490.6	(54,064.3)
Нийт орлого ба тусламжийн дүн	278,425.7	340,315.1	(61,889.4)
Татварын орлого	278,425.7	340,315.1	(61,889.4)
Орлогын албан татвар	153,400.0	163,421.4	(10,021.4)
Хувь хүний орлогын албан татвар	153,400.0	163,421.4	(10,021.40)
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	112,600.0	141,232.7	(28,632.7)
Үйл ажиллагааны орлого	13,000.0	10,647.7	2,352.3
Шууд бус орлого	27,800.0	11,541.0	16,259.0
Хөрөнгийн албан татвар	35,460.0	36,360.9	(900.9)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	200.0	2,015.9	(1,815.9)
Бууны албан татвар	2,260.0	1,230.0	1,030.0
Малын тоо толгойн албан татвар	-	8,383.1	(8,383.1)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	33,000.0	24,731.9	8,268.1
Бусад татвар, төлбөр, хураамж	89,565.7	140,532.8	(50,967.1)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,320.0	7,804.7	(1,484.7)
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,069.1	(69.1)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	3,360.0	4,095.0	(735.0)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	960.0	1,640.6	(680.6)
Газрын төлбөр	4,795.7	2,912.7	1,883.0
Газрын төлбөр	4,795.7	2,912.7	1,883.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	78,450.0	129,815.4	(51,365.4)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	76,950.0	128,576.5	(51,626.5)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,000.0	793.9	206.1
Ойн нөөцийн төлбөр			-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	500.0	445.0	55.0
Татварын бус орлого	13,000.6	5,175.5	7,825.1
Торгуулийн орлого	13,000.0	5,175.0	7,825.0

Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.6	0.5	0.1

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 345.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 28.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 0.8 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.6 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.7 сая төгрөгөөр тус тус орлого давж , үйл ажиллагааны орлого 2.3 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 8.3 сая төгрөг, шууд бус орлого 16.2 сая төгрөг, бууны албан татвар 1.0 сая төгрөг, ус рашаан ашигласны татвар 0.2 сая төгрөг. Шууд бус орлого 16.2 сая төгрөг , газрын төлбөр 1.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10.0 сая төгрөг, бусад орлогоос 12.6 сая төгрөг бүгд 22.6 сая төгрөгийг төвлөрүүлэн бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд 22.6 сая төгрөг тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул, гэрээт аудитор М.Энхжаргал нар 2022 оны 03 дугаар сарын 21-нээс 03 дугаар сарын 25–ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 1/51 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,233.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 24.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 19.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвөөс хэвлэл, захиалгын зардал гаргаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж 71.3 сая төгрөгийн 4 албан шаардлага 234.6 сая төгрөгийн 8 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн 85 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.2	1	0.2		-	100
Албан шаардлага	4	71.3	2	53.9	2	17.4	76
Зөвлөмж	8	234.6	6	184.6	2	50	79
Нийт дүн	**13**	**306.1**	**9**	**238.7**	**4**	67.4	**85**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 30.0 сая төгрөгийн малжуулах төслийн зээлийн авлагын хугацаа дуусантай холбоотой хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 2.8 сая төгрөгийн алдааг залруулаа.Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Авлагын залруулах бичилт хийхдээ зардал найдваргүй авлагын зардал дансанд бичиж үр дүнг буруу илэрхийлсэн бүртгэснийг авлага дансанд, Үндсэн хөрөнгө бодитойгоор оршин байхгүй байхад дансанд бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 111.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 111.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.2 Зөвлөмж

5.2.1 Авлагын данстай холбоотой

Илрүүлэлт: "Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 121.3 сая төгрөгийн авлагыг бууруулах талаар тодорхой ажил хэрэгжүүлээгүй. Үүнээс малжуулах төслийн 30.0 төгрөгийн авлагыг эргэлтэд оруулаагүй, өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй, зөрчил нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж *: Насажсан авлагыг барагдуулж тооцоо нийлж дотоод хяналт хэрэгжүүлэх*

5.2.2 *ОНХС-ийн зарцуулалттай холбоотой асуудал*

Илрүүлэлт: ОНХС -хөрөнгө оруулалтаар Ковш трактор худалдан авах, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалны шалны их засвар, дотуур байрны 00-ын засвар, олон үндэстэн ястны өв соёлын хөтөлбөр зэрэгт 81.2 сая төгрөгийг зарцуулсан. Ингэхдээ орон нутгийн иргэдээс санал авалгүй, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6 -д Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлж алдааг давтан гаргахгүй ажиллах

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

5.2.3 Цалин хөлс, зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын 04 тоот захирамжаар 2022 оны 3 сарын 31-нд ИТХ-ын нарийн бичгийн дарга өндөр насны тэтгэвэрт гарсан тул ИТХ-ын 07 тоот захирамжаар Засаг даргын нийгмийн бодлогын ажилтанд уг ажлыг хавсран гүйцэтгүүлэхээр захирамж гаргасан мөн ИТХ-ын 06 тоот захирамжаар олон нийттэй харилцах асуудал хариуцсан гэрээт ажилтан авч ажиллуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54.3 ажлын албаны дарга нь тухайн хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэн батлагдсан орон тоогоор ажиллах

5.2.4 ***Зардалтай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Худалдан авсан шатахууны тайлан гаргалт хангалтгүй, шатахууны талонд даргын тамга гарын үсэг зуруулаагүй, мөн шатахууны тоог зассан 0.7 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.. 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэн шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагын залруулах бичилт хийхдээ зардал дансанд бичиж үр дүнг буруу илэрхийлсэн	1	0.05			1	0.05	-	0.05
Үндсэн хөрөнгө бодитойгоор оршин байхгүй байхад бүртгэсэн	1	2.0			1	2.0	1	2.0
Дүн	2	2.1	-		2	2.1	1	2.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн санал авч, эрэмбэлээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, зарцуулсан.	1	81.2	1	81.2				
Батлагдсан бүтэц, орон тооноос илүү ажиллуулсан байна	1		1					
Шатахууны талон Даргын тамга гарын үсэг зуруулаагүй, мөн шатахууны тоог зассан.	1	0.7	1	0.7				
Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн балансад бүртгэлтэй 121.3 сая төгрөгийн авлагыг бууруулах талаар тодорхой ажил хэрэгжүүлээгүй. Үүнээс малжуулах төслийн 30.0 төгрөгийн авлагыг эргэлтэд оруулаагүй	1	30.0	1	30.0				
Дүн	**3**	**111.9**	**3**	**111.9**	-	-	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР: 8417143692 **Д.НАРАНТУУЛ**

ПЮА0073 9066454

ГЭРЭЭТ АУДИТОР **М.ЭНХЖАРГАЛ**